



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/342

Эрдэнэт

### Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/, 29.2 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 10.1.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2017 оны ахмадын зуны саам сувилалыг ажиллуулж шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагааны зардалд шаардагдах 35000000 /Гучин таван сая / төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын "Ахмадын зуны саам сувилал зардал"-аас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3.Ахмадын зуны саам сувилалыг чанартай зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс /н.Бумансор/, аймгийн Ахмадын хороо /н.Амаржаргал/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д. БАТЛУТ



Аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 27 дугаар захирамжийн хавсралт

СААМ АМРАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Амрах хүний тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Булагт Хангай саам амралт	115	130 000	14 950 000
2	Арбулаг саам амралт	75	130 000	9 750 000
3	Очир Увидас саам амралт	75	130 000	9 750 000
4	Ээлж бүрт хяналт шалгалтаар явах машины шатахуун	6 x 50,5л	1650	500 000
5	Нийт			35 000 000